

**Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн**

**саналын товчоон**

2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

| № | Хаанаас   | Саналын агуулга  | Хуулийн төсөлд тусгасан санал | Хуулийн төсөлд тусгаагүй санал  |
|---|---|--|-------------------------------|---|
| 1 | МОНГОЛ УЛСЫН<br>ЗАСГИЙН ГАЗАР   | Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12 дахь хэсэгт заасны дагуу тусгайлан өгөх саналгүй.  | —                             | —   |
| 2 | УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН<br>ЕРӨНХИЙ ШҮҮГЧ<br>Д.ГАНЗОРИГ<br>2020.11.04 2/4492      | Зарчмын хувьд дэмжих боломжгүй байна. Хэн нэгэн хүнийг албаны бүрэн эрхээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулж хардаж сэрдэх нь “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн зарчимд нийцэхгүй байна. |                               | Монгол Улсын Үндсэн хуульд заасан итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалах хүрээнд хүний алдар хүндийг зохистой хүрээнд хязгаарлах зарчим, олон улсын гэрээ, эрх зүйн зарчимд нийцсэн тул эрх тэгш байх зарчим зөрчигдөхгүй байна. |
| 3 | ХҮНИЙ ЭРХИЙН<br>ҮНДЭСНИЙ КОМИССЫН<br>ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР<br>ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ | Дэмжиж байна   | —                             | —   |

|   |   |   |   |  |
|---|---|---|---|--|
|   | <p>П.ОЮУНЧИМЭГ</p> <p>2020.09.22 3/599</p>  |   |   |  |
| 4 | <p>ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН<br/>ЗӨВЛӨЛИЙН ГҮЙЦЭТГЭХ<br/>ЗАХИРАЛ Д.ГҮНЖИДМАА</p> <p>2020.09.25 01/152</p> | <p>Дэмжиж байгаа бөгөөд хуулийн төслийн ерөнхий заалтад нэмэлт тодотгол хийх санал дэвшүүлж, нэмэлт тайлбарын томъёоллыг илүү оновчтой болгох шаардлагатай</p> <p>Мөрдөгдөж буй хууль болон хуулийн төсөлд өгөх санал: 13.14 Худал мэдээлэл тараах Гүтгэх</p> <p>Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг <b>худал баримтыг зориудаар</b> олон нийтэд тараасан бол ...</p> <p>Нэмэлт оруулахаар төлөвлөж буй тайлбарт өгөх санал: “улс төрд нөлөө бүхий этгээд”, “төрийн байгууллага” гэсэн нэр томъёо нь тодорхойгүй байдлыг үүсгэж байна</p> <p>“хардсан, сэрдсэн” гэдэг ойлголт нь тухайн зүйлийн үнэн/зөв эсвэл худал болохыг хараахан тогтоогоогүй байгаа явдал билээ. Сэтгүүл зүйн ёс зүйн зарчимд хардсан, сэрдсэн, баталгаагүй мэдээллийг сэтгүүлчид сурвалжилж мэдээлж болох ч үүнийгээ таамаг, баталгаагүй мэдээлэл гэдгийг заавал</p> | <p>Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн гарчгийг Худал мэдээлэл тараах бус Гүтгэх гэж өөрчлөх саналыг хуулийн төсөлд тусган авсан.</p> | <p>2015 оны Эрүүгийн хуульд “улс төрд нөлөө бүхий этгээд” гэдгийн тайлбараар тодорхойлсон байх тул нэр томъёоны ойлгомжгүй байдал үүсэхээргүй байна.</p> |

|   |   |   |   |   |
|---|---|---|---|---|
|   |   | <p>дурьдаж олон нийтэд түгээхийг сануулдаг. Хэрэв сэтгүүлчид “таамаг, баталгаагүй мэдээлэл” гэдгийг дурьдалгүйгээр мэргэжлийн алдаа гаргавал өөрийн зохицуулалтаар залруулах боломж олгодог. Иймд хуулийн нэмэлт тайлбарт оруулахаар төлөвлөж буй “хардалт, сэрдэлт” хэмээх нэр томъёо нь хуулийн хүрээг өргөжүүлж, хэвлэлийн эрх чөлөөнд хязгаарлалт үзүүлэх нөлөө болж болзошгүй тул ийм асуудлыг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмаар зохицуулах боломжтой юм.</p> |   |   |
| 5 | <p>МОНГОЛЫН<br/>КРИМИНОЛОГИЧДЫН<br/>ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ<br/>ЗАХИРАЛ М.СҮХБААТАР<br/>2020.09.30 2020/24</p> | <p>...Иймд албаны бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаатай нь холбогдуулан иргэд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын зүгээс гаргасан хардалтын талаар худал мэдээлэл түгээсэн гэж гэмт хэрэгт тооцохгүй байх зэрэг эерэг үр дагавар бүхий зохицуулалт болжээ. Энэ нь олон улсын гэрээний (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт) болон гэрээний бус (Хүний эрхийн түгээмэл тунхаглал) хэм хэмжээ дэх хүний эрхийн стандартад нийцүүлэн төсөлд тусгаснаа илэрхийлж байна.</p>      | — | — |